

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД, ӨМНӨГОВЬ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН ХООРОНД 2025 ОНД БАЙГУУЛСАН
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ГҮЙЦЭТГЭСЭН
ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 22

Даланзадгад хот

Нэг.Хяналт-шинжилгээний зорилго

Салбарын хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, урт болон дунд хугацааны бодлогод туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр байгуулсан хамтран ажиллах гэрээний үүргийн хэрэгжилтийг дүгнэх, хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхийг арга хэмжээ тус бүрээр тодорхойлж, санал, зөвлөмж боловсруулах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад оршино.

Хоёр.Хяналт-шинжилгээг гүйцэтгэх үндэслэл, арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, хамтран ажиллах гэрээний 5 дугаар бүлгийн 5.1 дэх зүйлийг тус тус үндэслэв.

Хяналт-шинжилгээний ажлын явцад аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн холбогдох мэргэжилтнээс тайлан, мэдээний хэрэгжилтэд шаардлагатай нэмэлт тодруулга буюу гүйцэтгэлийн үр дүнг нотлох тайлбарыг авах замаар мэдээллийн чанарыг сайжруулан бататгаж дүгнэв.

Гурав.Хяналт-шинжилгээний үр дүн

3.1.Гэрээний ерөнхий мэдээлэл

Хамтран ажиллах гэрээний хавсралтаар дараах 5 зорилтын 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 1

Д/д	Зорилт	Арга хэмжээний тоо
1.	Мал, аж ахуйн үйлдвэрлэл	10
2.	Газар, тариалангийн үйлдвэрлэл	4
3.	Хүнс үйлдвэрлэл	9
4.	Хөнгөн үйлдвэрлэл	4
5.	Жижиг, дунд үйлдвэрлэл	5
Нийт		32

3.2.Гэрээний хэрэгжилтийн мэдээлэл

Хамтран ажиллах гэрээний хавсралтаар батлагдсан 32 арга хэмжээний жилийн эцсийн хэрэгжилтийн тайлантай танилцахад:

- Хэрэгжсэн- 28;
- Хэрэгжээгүй- 4 арга хэмжээ байна.

Гэрээний хавсралтаар батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2

Д/д	Чиглэл	Нийт арга хэмжээ	Хэрэгж -сэн	Хэрэгжээ -гүй	Хугацаа болоогүй
1.	Мал, аж ахуйн үйлдвэрлэл	10	7	3	-
2.	Газар, тариалангийн үйлдвэрлэл	4	4	-	-
3.	Хүнс үйлдвэрлэл	9	9	-	-
4.	Хөнгөн үйлдвэрлэл	4	4	-	-
5.	Жижиг, дунд үйлдвэрлэл	5	4	1	-
Нийт		32	28	4	-

“Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 3 дугаар бүлгийн 3.7.2 дахь заалтын дагуу “Хэрэгжээгүй” (шийдвэрийн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил боловсруулалтын шатанд байгаа, төсөв шийдэгдсэн боловч хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй) 4 арга хэмжээний шалтгаан, нөхцөлийг доор тайлбарлав. Үүнд:

Хүснэгт 3


Д/д	Арга хэмжээ		“Хэрэгжээгүй” гэж дүгнэх шалтгаан
	Дугаар	Нэр	
1.	1.4	Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг, ангилалт хийж цөм сүргийг бүрдүүлэх /airs.mofa.gov.mn/, /muz.gov.mn/ зэрэг сайтуудад мэдээллийн сан бүрдүүлэх;	Хүрэх түвшинд хүрээгүй байна.
2.	1.5	Эрчимжсэн аж ахуйд үржүүлж байгаа үхрийг малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх;	Санхүүжилт байхгүйгээс уг ажил хийгдээгүй байна.
3.	1.7	Бог малын хээлтүүлэгчийг мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтад шилжүүлж ялган төвлөрүүлэх;	Хүрэх түвшинд хүрээгүй байна.
4.	5.2	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн чанаргүй муу зээлийн хэмжээг бууруулахад онцгой анхаарч, зээл төлүүлэх асуудлаар хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах;	Хүрэх түвшинд хүрээгүй байна.

Дөрөв.Дүгнэлт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын Өмнөговь аймгийн Засаг даргатай 2025 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилтийг хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхэд аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс ирүүлсэн 88.6%-ийн үнэлгээ бүхий тайлантай танилцаж, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу хяналт-шинжилгээг гүйцэтгэн 87.5% буюу “Үр дүн гарсан” гэж дүгнэв.

Гэрээний хэрэгжилтийн хувийг сүүлийн 5 жилийн байдлаар харьцуулан харуулав.

График 1



Тайлангийн хэрэгжилт сүүлийн таван жилийн хугацаанд өсөлт, бууралтын хэлбэлзэлтэй байгаа нь салбарын холбогдох байгууллагууд үйл ажиллагаагаа улам чанаржуулж, тайлан, баримт бичгийн бүрдүүлэлт, гүйцэтгэлийн үнэлгээний бодит байдлыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс ирүүлсэн тайлан чанарын хувьд харьцангуй сайн, шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнасан байгаа хэдий ч Сайдын гэрээний хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг бүх аймагт ижил байдлаар баталж байгаа нь орон нутгийн ялгаатай хэрэгцээ, чадавх, нөөц бололцоог тусгах боломжийг хязгаарлаж, үр дүнд суурилсан төлөвлөлт хийхэд саад болж байна. Үүний улмаас зарим үзүүлэлт бодит нөхцөлд хүрэх боломжгүйгээр тодорхойлогдож, төлөвлөгөөний хэрэгжилт болон тайлангийн биелэлт хангалтгүй үнэлэгдэх нөхцөл үүсэж байна.

Иймд Сайдын гэрээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тухайн оны эхэнд баталж, хэрэгжилтийг жилийн турш төлөвлөгөөний дагуу зохион байгуулан ажиллах нь зорилт, арга хэмжээний уялдаа, гүйцэтгэлийн тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой гэж үзэж байна.

Тус гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд тайлант хугацаанд:

- Улсын төсвөөс- 61,9 сая;
- Орон нутгийн төсвөөс-12,2 тэрбум;
- Бусад эх үүсвэрээс-2,3 тэрбум төгрөгийг тус тус зарцуулж дараах үр дүнтэй ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Тухайлбал:

- 2025 онд улсын төсвийн 61,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2, орон нутгийн төсвийн 1,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 32 инженерийн хийцтэй худаг шинээр гаргаж, бэлчээрийн 13 худгийг нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрээр тоноглох ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн сумдын орон нутгийн хөгжлийн сан, төсөл хөтөлбөрийн 2.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 63 инженерийн хийцтэй худаг шинээр гаргаж, 26 худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүр суурилуулж, 28 инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худгийг сэргээн засварлаж, аймгийн бэлчээр усжуулалтыг 66%-д хүргэсэн.
- Голомтлон гардаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 468140 толгой мал хамруулахаар төлөвлөснөөс 490455 толгой мал, амьтныг хамруулж 104%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.
- Мод үржүүлгийн 1-р талбайд алим 72 ширхэг, чавга 86 ширхэг, өрөл 408 ширхэг, үхрийн нүд 340 ширхэг, интоор 54 ширхэг, чацаргана 100 ширхэг зэрэг нийт 1060 ширхэг жимсний модыг эх үрийн талбай болон танин

мэдэхүйн талбай, бойжуулалтын талбайд тус тус тарималжуулсан ба 10 сарын судалгаагаар модны амьдралт 100 хувьтай ургаж байна.

- “Гүүд Рүүд интер трейдинг” ХХК-ийн шинэ үйлдвэр нь 2025 онд ашиглалтад орж, үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 3%-аар, гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч “Ганган тайж” ХХК нь үйлдвэрээ өргөтгөн 15 ажлын байр, үйлдвэрийн хүчин чадлаа 22.5%-аар тус тус нэмэгдүүлсэн байна.
- Аймгийн хэмжээнд 2025 онд 1491 тонн мах үйлдвэрийн аргаар бэлтгэсэн нь аймгийн хүн амын хэрэгцээний 17%-ийг хангаж байна.
- Ингэний сүү боловсруулах үйлдвэр нь 2024 онд зөвхөн ингэний хоормог үйлдвэрлэж байсан бол 2025 онд ингэний сүүн тараг, хуурай сүү үйлдвэрлэж нэр төрлөө нэмсэн байна.
- Аймгийн хэмжээнд 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн “Үдийн хоол”, “Дотуур байр”, “Цэцэрлэгийн хүүхдийн хоол”-ны нэгдсэн “Тэнцвэртэй жишиг” 3 төрлийн 4 долоо хоногийн цэсийг Боловсролын байгууллагын хоол зүйчдийн хамтарсан баг боловсруулан хэрэгжүүлж, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын цэсэд 5 өдрийн 3 өдөрт 100-200гр сүү, сүүн бүтээгдэхүүн, дотуур байранд 7 өдрийн 5 өдөрт 150-200гр сүү, сүүн бүтээгдэхүүн олгож байна.
- Говийн болон зүүн бүсийн аймгуудын аварга тогооч, зөөгч шалгаруулах “Буурч цом-2025” ажил мэргэжлийн ур чадварын уралдааныг аймагтаа амжилттай зохион байгуулсан байна.
- 2025 онд төрийн худалдан авалтад 145 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулсан ба үүнээс худалдан авах ажиллагааны шалгуур үзүүлэлтэд “Дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжих” бодлогын хүрээнд 44 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Нийт зохион байгуулсан ажлын 30.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх онтой харьцуулахад нийлүүлэлтийн түвшин 16.6 хувиар нэмэгдсэн байна.
- Цогт-Овоо суманд хоногт 30 бог, 10 бод мал нядлах хүчин чадал бүхий мал нядалгааны газрыг 546.5 сая төгрөгөөр гүйцэтгүүлж, барилгын ажлыг ашиглалтад хүлээн авсан байна.
- Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд нийт 3141 малчин өрхийн 1267721 толгой мал хамрагдсан бөгөөд мал угаалгад 1510 өрхийн 641596 толгой мал, туулгалтад 683 өрхийн 242384 толгой мал, боловсруулалтад 966 өрхийн 383741 толгой малыг хамруулан 97.5 хувийн гүйцэтгэлтэй, шимэгчтэх өвчний гаралтыг урьд оноос 15%-аар бууруулсан байна.
- “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд малчдын бэлтгэсэн арьс ширэн түүхий эдийг Номгон сумын “Лусын сэрчим”, “Хөрхийн наран” хоршоодоор дамжуулан 40 тонн арьс шир, 80 тонн ноос ноолуурыг үндэсний боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн байна.
- 2025 онд малчдын хоршоонд Ханбогд суманд 4 нэгж талбар, Гурвантэс суманд 7 нэгж талбар, нийт 18.94 га газрыг малчдын хоршоонд олгож, хоршоо хөгжүүлэх сангаас 4 сумын 10 хоршоо журмын шаардлага ханган

488,810,000 төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, 24 ажлын байр хадгалж, 15 ажлын байр шинээр бий болгосон байна.

- Орон нутаг болон хувийн хэвшлийн 6,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар жилд 160.0 мянган тонн ноос боловсруулах хүчин чадал бүхий "Хонь, тэмээний ноос боловсруулах" үйлдвэрийг байгуулсан байна.
- "Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын дагуу орон нутгийн 50 аж ахуй нэгж 8.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, 220 ажлын байр хадгалагдаж, 249 ажлын байр шинээр бий болсон байна.
- Хоршоо хөгжүүлэх сангийн муу ангиллын 63 зээлдэгчийн 1,233,203,000 зээлийн зөрчлөөс Иргэний хуулийн анхан шатны шүүхэд 8 зээлдэгч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт анхан шатны шүүхийн шийдвэр гарсан 12 зээлдэгч, Иргэний хуулийн анхан шатны шүүхээс дараагийн шатанд 3 зээлдэгчийн шийдвэрийг хүргүүлж, шүүгчийн захирамжийн дагуу үлдсэн зээлдэгчидтэй эвлэрүүлэн жуучлах ажлын хүрээнд 246,539,878 төгрөгийн зөрчлийг арилгаж, чанаргүй зээлийг 13.2 хувиар бууруулсан байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Ноён суманд нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилгыг 2025 оны 4 дүгээр сарын 23-нд хүлээн авч, алслагдсан Ноён суманд нийтийн ахуй үйлчилгээ эрхлэгчид нэг дор төвлөрсөн байртай болсноор тасралтгүй үйл ажиллагаа явуулах, үүнийг дагасан ажлын байр бий болох, иргэд ая тухтай үйлчилгээг авах нөхцөл бүрдсэн байна.

Тав.Зөвлөмж

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд болон Өмнөговь аймгийн Засаг даргын хооронд 2025 онд байгуулсан гэрээний жилийн эцсийн хэрэгжилттэй танилцах явцад арга хэмжээнд зарцуулсан төсвийн эх үүсвэрийг тодорхойлох, мөн тайлангийн найруулгад анхаарч ажиллах шаардлагатай байна.

ТАНИЛЦСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Н.ЭНХБАТ

ТАЙЛАН ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.УЯНГА

ТАЙЛАН БИЧСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.БЯМБАДЭЛГЭР

